

Сургуулиас хөөх тухай мэдэгдэл - санаа зовоосон ноцтой зан авир

Утсан орчуулгын үйлчилгээг ашиглан сургуультай холбогдох нь

Сурагчийн нэр
Name of student

Эрхэм хүндэт эцэг эх/асран хамгаалагч танаа

Хавсаргасан захидалд NSW мужийн Боловсролын Яамны Сурагчийн Зан Авирын Тухай Бодлого, мөн Сургуулиас Түр Чөлөөлөх болон Хөөх Журмын дагуу таны хүүхдэд өгсөн “Сургуулиас хөөх тухай мэдэгдэл - санаа зовоосон ноцтой зан авир”-н тухай дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан болно.

Бид уг сурагчийг хичээл, сургалтанд хамрагдах өөр боломжийг тодорхойлж байх хугацаанд таны хүүхэд сургуулиас түр чөлөөлөгдсөн хэвээр байх болно. Сургуулийн ажилтан тантай холбогдож дараагийн хийх алхмуудыг тайлбарлана.

Хүүхэд тань сургуулиас хөөгдсөн тохиолдолд таны мэдэх шаардлагатай мэдээллийг бид энд хавсаргав.

Хэрэв танд хавсаргасан захидлыг ойлгоход хүндрэлтэй байвал сургуультай холбоо барина уу. Бид танд тайлбарлаж өгөх болно. Хэрвээ та хүүхдийнхээ сургуультай холбогдох хүсэлтэй бөгөөд танд англи хэлний тусламж хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт залган өөрийн ярихыг хүссэн хэлээ мэдэгдэн, сургуультай холбож өгөхийг хүсээрэй. Оператор таны яриаг орчуулах орчуулагчийг шугамд холбож өгөх болно. Уг үйлчилгээ нь үнэ төлбөргүй.

Захирлын нэр
Name of Principal

Захирлын утасны дугаар
Principal's phone number